



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2014 оны 05 сарын 21 өдөр

Дугаар 172

Улаанбаатар хот

“Тэгш” ХК-ийн үнэт цаасыг  
бүртгэлээс хасах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 63.1.10, Компанийн тухай хуулийн 23 дугаар зүйл, Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 77 дугаар тогтоолын 4.2 дахь хэсэг, 2014 оны 06 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 22 дахь зүйлийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Тэгш” ХК-ийн нийтэд санал болгон гаргасан нийт 156,857 /нэг зуун тавин зургаан мянга найман зуун тавин долоо/ ширхэг хувьцааг үнэт цаасны бүртгэлээс хасахыг Үнэт цаасны газар /Т.Жамбаажамц/, хөрөнгийн биржийн жагсаалтаас хасахыг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Д.Болормаа/, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн бүртгэлээс хасахыг “ҮЦТТТХТ” ХХК /Т.Гандулам/-д тус тус үүрэг болгосугай.
2. Компанийн тухай хуулийн 24.1, 53.1 дэх заалтын дагуу өөрийн эзэмшиж байгаа хувьцааг компанид эргүүлэн авахыг шаардах эрх үүссэн хувьцаа эзэмшигчдэд уг эрх үүссэн тухай болон түүнийг хэрэгжүүлэх журмын талаарх мэдээллийг энэхүү тогтоол батлагдсан өдрөөс хойш ажлын 5 хоногт багтаан өдөр тутмын хэвлэл, мэдээллийн хэрэгсэлээр дамжуулан мэдээлэхийг “Тэгш” ХК /П.Мягмардаваа/-д үүрэг болгосугай.
3. Шаардах эрхээ хэрэгжүүлээгүй хувьцаа эзэмшигч түүний дансанд байршуулсан ногдол хувийн мөнгөн хөрөнгийг авалгүйгээр хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьцаа эзэмшигчээр үлдэх хүсэлтийг хэдийд ч гаргаж болохыг тэмдэглэсүгэй.
4. Тус компани хэлбэрээ өөрчилж, үнэт цаасны бүртгэлээс хасагдаж байгаатай холбогдуулан “Тэгш” ХК /П.Мягмардаваа/, “ҮЦТТТХТ” ХХК /Т.Гандулам/-д дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг үүрэг болгосугай:
  - 1/ Хувьцаагаа компанид эргүүлэн худалдан авахыг шаардах эрх үүссэн хувьцаа эзэмшигчдийн эзэмшилд байгаа хувьцаанд оногдох ногдол хувийн мөнгөн хөрөнгийг нэгж хувьцаанд 11,876 /арван нэгэн мянга найман зуун далан зургаа/ төгрөгөөр тооцон “ҮЦТТТХТ” ХХК-тай гэрээ байгуулж, үнэт цаасны төвлөрсөн хадгаламж дахь хувьцаа эзэмшигчдийн холбогдох дансанд энэхүү журам батлагдсан өдрөөс хойш ажлын 15 хоногийн дотор шилжүүлж хувьцаа эзэмшигчдийн шаардах эрхийг хэрэгжүүлэх нөхцлийг хангах;

2/ Хувьцаа эзэмшигч өөрийн эзэмшиж буй хувьцааг компанид эргүүлэн худалдан авах шаардлагыг гаргасан тохиолдолд зохих журмын дагуу нэгж хувьцаанд оногдох ногдол хувийн мөнгөн хөрөнгийг хувьцаа эзэмшигчдэд шуурхай олгох;

3/ Ногдол хувийн мөнгөн хөрөнгийг төвлөрсөн хадгаламж дахь дансанд байршуулахдаа хувьцаагаа компанид эргүүлэн худалдан авахыг шаардах эрх тухайн дансны эзэмшигчид үүссэн тухай тэмдэглэл хийж, харилцагч дансны хуулга авах тухай бүрд зохих тайлбарыг өгч ажиллах;

4/ Энэхүү тогтоолын 3-т заасан хүсэлтийг гаргасан тохиолдолд компанийн эзэмшил дэх хувьцаанаас хүсэлт гаргасан хувьцаа эзэмшигчид эзэмшүүлж, түүний хариуд уг хувьцаа эзэмшигчийн төвлөрсөн хадгаламжийн байгууллага дахь дансанд нь байршуулсан ногдол хувийн мөнгөн хөрөнгийг тус компанид шилжүүлж ажиллах.

5. Тогтоол батлагдсанаас хойш ажлын 10 хоногийн дотор Улсын бүртгэлийн ерөнхий газарт мэдээлэл хүргэх, тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН